

ЧОНО

Мо Еэнь

Тэр чоно манай бүдүүн гахайны зургийг нууцаар дарчихжээ. Түүнийг гүүрний дэргэдэх зурагчинд очиж зургаа угаалгана гэдгийг би мэдэж байсан тул тэнд нь түрүүлж очоод хаалганы ард нуугдан хүлээж байлаа. Нохой маань бас намайг дагаж ирээд дэргэд минь оцойн сууж байв.

Өглөө арван цаг дөхөж байхад чоно ирлээ. Тэр цагаан царайтай дунд насны эр болон хувирчээ. Гялалзтал нь угаасан цэнхэр өнгийн хакихятад хослол өмсөж, ханцуй дээр нь хэсэг газар шохойболсон нь яг л дунд сургуулийн тооны багш гэлтэй. Түүнийг чоно гэдгийг би мэдэж байлаа. Чоно лангууны өмнө тонгойн зогсоод энгэрээсээ зургийн хальс гаргаж үйлчлэгчид өгөх гэж байтал нохой маань түүн рүү дайран очиж хонгыг нь зуун авлаа. Чоно чангаар орилов. Орилох дуу нь тун ч гаслантайсонсогдоно. Түүний сүүл өмдөн дотроо овойж ирмэгцээ тэр даруйдаа эргээд хэвэндээ орчихов. Тэгж би түүнийг агшин зуурт сэтгэлийн хөдлөлөө тогтоон барих асар их чадвартай гэдгийг мэдсэн юм.

Нохой маань түүнийг зууж байснаа болиод гүйн одов. Би харвасан сум шиг дайран очиж зургийн хальсыг булаан авлаа. Лангууны ард байсан үйлчлэгч энэ явдалтай эвлэрч чадалгүй: “Хөөе чи, ямар дээрэнгүй юм бэ?” гэв. “Наадах чинь чоно байхгүй юу” хэмээн би хашгирлаа. Харин чоно өрөвдөлтэй дүр эсгэн чимээгүйхэн хүйтнээр жуумалзана. “Зургийн хальсыг эзэнд нь буцааж өг!” гэж үйлчлэгч хашгирав. Гэтэл чоно хэдийн гэдрэг эргээд үүд рүү зүглэн байлаа. Намайг араас нь даган үүд хүрэхэд гудамж хов хоосон, түүний бараа сураг ч үгүй болсон байв. Ганц болжмор л халуухан хомоол тоншиж харагдана.

Намайг гэртээ ирэхэд манай нөгөө бүдүүн гахай аль хэдийн чононд гэдсээ хүүлүүлсэн байх нь тэр. Нохой минь хүнд шархдаад хананы буланд шархаа долоон сууж байлаа.

Хятад хэлнээс орчуулсан: Бат-Очирын Гэрэлт-Ирээдүй¹⁹⁰

¹⁹⁰ МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхимийн дэд проф, доктор (Ph.D)